

Шинэ залуу багш нарынхаа мэдлэг боловсрол, ур ухааныг хослуулан хөгжүүлэх нь



Орхон аймгийн ЕБС – иудын Дизайн технологи, дүрслэх урлаг, зураг зүйн багш нарын дунд МУ – ын Зөвлөх багш, БТА, Боловсрол судлалын магистр Л. Даваадоржийн нэрэмжит ур чадварын уралдаан 10 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү уралдаан шинэ залуу багш нарын мэдлэг боловсрол, заах арга, ур чадварыг дээшлүүлэх, хамтын үйл ажиллагааг сайжруулах, ажлын арга барилаа солилцох зорилготой юм. Ур чадварын уралдаанд 10 сургуулийн 13 багш нар оролцсноо Дизайн

технологийн судалагдахууны агуулгаар 8 –р лаборатори сургуулийн багш Д. Ширнэн тэргүүн байр, 2 –р байр 5 сургуулийн багш С. Лхамдолгор, 3 –р байр 17 –р сургуулийн багш Б. Мягмарзагд, Дүрслэх урлагийн судлагдахууны агуулгаар 3 –р сургуулийн багш С. Цэрэнчимэд тэргүүн байр, 2 –р байр 14 сургуулийн багш Ш. Гантулга, 3 –р байр Орхон эмпати сургуулийн багш О. Мягмарзаяа нар шалгарав.



Залуу багш нартаа шагналаа гардуулав.



Д. Ширнэн , С. Лхамдолгор



Дизайн технологи, дүрслэх урлаг, зураг зүйн багш нар



Ш. Гантулга



Д. Эрдэнэжаргал



С. Цэрэнчимэд

Орхон аймгийн БСУГ –ын дэргэдэх Боловсролын байгууллагуудын “ **Зөвлөх багш нарын зөвлөл** “ ийн гишүүн багш нар гурван багт хуваагдаж, 2, 15, 16 –р сургуулийн багш нарт зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн нь багш нарын сэтгэлд нийцсэн сайхан ажил болсон . Аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын дэргэдэх Боловсролын байгууллагуудын “ Зөвлөх багш нарын зөвлөл “ ийн гишүүдтэй хамтран Мэргэжлийн багш нарынхаа заах арга ур чадварыг дээшлүүлэх чадамжтай багш боловсон хүчин бэлтгэхэд өөрийн анхаарлаа чиглүүлэн ажиллаж, багш нарын дунд орон нутгийн , сургуулийн хэмжээнд сургалтуудыг амжилттай зохион байгуулж байна.

- Багш нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, багш ажлын байранд хөгжиж багшлах арга зүйгээ нь өөрчлөх, өөрийн арга туршлагаа түгээн дэлгэрүүлэх, сургалтын ажлын чанар, түвшинг сайжруулах зорилгоор тус үйл ажиллагааг ЕБ –ын 16 – р сургууль дээр

2019 оны 05 сарын 17 ны өдөр 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр зөвлөн туслах II баг ажиллаж, дараахь ажлуудыг хийлээ.

- 5 зөвлөх , 1 тэргүүлэх багш , ганцаарчилсан , хамтын хичээлүүдийг зааж,хичээлд давхардсан тоогоор 110 багш сууж, хичээлд ажиглалт, дүгнэлт хийв.
- Хичээл ажиглаж буй багш нар бүтээлч оролцоотой, хариуцлагатай байхыг бид бүхэн чухалчилсан .
- “ Зөвлөх багш нарын бүтээл “ ийн үзэсгэлэн гаргаж, харилцан туршлагаа солилцсон нь хамт олны сэтгэлд нийцсэн ажил болсон.
- Зөвлөх багш нар Хичээл, сургалт семинарын дундуур бага, дунд ангийн нийт 9 цагийн хичээлд ажиглалт хийж ,тухайн хичээлийн хөтөлбөр, жил, нэгж болон ээлжит цагийн төлөвлөлттэй танилцаж, ололттой болон сул талаар хэлэлцэж ээлжит хичээлийн төлөвлөлтийг сайжруулах зөвлөгөөг өглөө.
- Бага, суурь боловсролын нийт давхардсан тоогоор 133 багш, удирдлагатай уулзаж ярилцан, сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч,ажилласан болно.
- Судлагдахуун тус бүрийн мэргэжлийн багш нартайгаа уулзаж хөтөлбөр, сурах бичгийн боловсруулалт, агуулгын сонголт,шийдэл, арга зүйн эзэмшилт, үнэлгээний хэрэгжилт бэрхшээлүүдийн талаар ярилцаж санал бодлоо солилцов.
- Тухайн орон нутгийн боловсролын байгууллага БСУГ, сургууль, багшийн хамтын ажиллагаа дээшилж, харилцан бие биенээсээ суралцан туршлага хуримтлуулж, зөвлөн туслах арга барилд тодорхой ахиц гарсан гэж үзэж байна
- Нэг өдрийн ажлын тайланг цомог байдлаар хийж, Аймгийн “ Зөвлөх багш нарын бүлгэм “ д байршуулж ажлын арга туршлага харилцан солилцож байна.

